УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2021 оны 06 сарын 04 өдөр Дугаар А/138 Улаанбаатар хот

Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай" 94 дүгээр тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны "Төлөвлөгөө батлах тухай" 113 дугаар тушаал, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-нд тусгагдсан холбогдох арга хэмжээг нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын явц, үр дүнг тухай бүр Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг /М.Балдандорж/-т үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ГАНТӨМӨР

C:\Users\Gantuya\Desktop\ҮЖ 12\doc 2021\тушаал 2.docx

1110300430

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2021 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн
А/138 тушаалын 1 хавсралт

"ТӨРӨӨС ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХУЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО"–ИЙН БАРИМТ БИЧИГТ ХОТ НИЙТИЙН АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР НИЙСЛЭЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ ГАРГАХ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч	М.Балдандорж	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүд	О.Оджаргал	Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын орлогч дарга
	Ч.Бум-Эрдэнэ	Хот байгуулалт, хөгжлийн газрын орлогч дарга
	Б.Азжаргал	Нийслэлийн Орон сууц, дэд бүтцийн газрын орлогч дарга
	С.Даваасүрэн	Нийслэлийн Мэргэжилийн хяналтын газрын дэд дарга
	Л.Буянтогтох	Нийслэлийн Боловсролын газар орлогч дарга
	Ч.Эрдэмбилэг	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
	Т.Оюунтөгс	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн
	Т.Халиунаа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн
	Ж.Чимэдцогзол	Чингэлтэй дүүргийн Засаг даргын орлогч
	Ц.Шижир	Сүхбаатар дүүргийн Засаг даргын орлогч
	С.Сайнбаяр	Хан-Уул дүүргийн Засаг даргын орлогч
	Д.Мөнхбаатар	Баянгол дүүргийн Засаг даргын орлогч
	Б.Батбаяр	Баянзүрх дүүргийн Засаг даргын орлогч
	Э.Ууганцэцэг	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын орлогч
	Б.Балжинням	Багануур дүүргийн Засаг даргын орлогч

	Г.Дагвадорж	Багахангай дүүргийн Засаг даргын орлогч
	С.Тунгалаг	Налайх дүүргийн Засаг даргын орлогч
	С.Дорждэрэм	Нийслэлийн орон сууцны корпорац ХК-ийн гүйцэтгэх захирал
	С.Батмөнх	Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ-ын дэд дарга
	Ж.Дагвасүрэн	Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын Ерөнхий инженер
	Ж.Мөнхцэцэг	Багануур ус ОНӨААТҮГ-ын Ерөнхий инженер
	З.Болдбаатар	Чандмань налайх ОНӨААТҮГ-ын Ерөнхий инженер
Нарийн бичгийн дарга	Д.Оюунжаргал	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга	Д.Сүхбат	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн